



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/146

Бор-Өндөр сум

**Нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах
тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дугаар зүйлийн 9.4, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хооронд “Нийтийн их цэвэрлэгээ”-г зохион байгуулсугай.

2.Нийтийн их цэвэрлэгээний ажлын төлөвлөгөө, хуваарийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3.Нийтийн их цэвэрлэгээнд өөрийн өрх гэр, байгууллагын орчин тойрон, хариуцуулж өгсөн нийтийн эзэмшлийн хуваарьт талбайг цэвэрлэж идэвхи санаачлагатай оролцохыг нийт иргэд, албан байгууллага, аж ахуй нэгжийн дарга эрхлэгч, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Нийтийн их цэвэрлэгээнд оролцоогүй албан байгууллага, ААНэгж, иргэдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох бөгөөд албан байгууллагын дарга, эрхлэгч нарт уг захирамжийн биелэлтийг хэрхэн хангаж ажилласнаар хагас, бүтэн жилийн үр дүнгийн гэрээг дүгнэхийг мэдэгдсүгэй.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Ууганжаргалд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ